

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

Дугаар

**Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх,
нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар
чиглэл өгөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг
үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахлын дотоодын халдвар бүртгэгдэж, өвчлөл дэгдсэнтэй холбогдуулан эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, өвчлөлийн цар хүрээ нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад тулгарах хүндрэлийг хохирол багатай даван туулах чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т, Монголбанк /Б.Лхагвасүрэн/-д, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/ нарт тус тус даалгасугай:

1/цар тахлын хүрээнд иргэн, аж ахуйн нэгж байгууллага, олон улсын хандивлагч байгууллагаас авсан зээл, тусламжийн зарцуулалтын явц, үр дүнг Улсын Их Хурал /Түр хороо/-д сар тутам тогтмол тайлагнах;

2/Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад хуулиудад өөрчлөлт оруулах, өвчлөлийн нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр тодорхой асуудлыг шийдвэрлүүлэх саналаа Улсын Их Хуралд танилцуулах;

3/жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор олон улсын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөд тулгуурласан нэн хөнгөлөлттэй, уян хатан зээл, тусламжийн шинэ эх үүсвэр бий болгох, уг арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх;

4/иргэд, аж ахуйн нэгжийн банк, банк бус санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүг бууруулах, зээл төлөлтийн хугацааг хойшлуулах болон хөнгөлөлт үзүүлэх чиглэлээр Монгол Улсын Их Хурлын 2020 оны "Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай" 32 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх;

5/цар тахлын үед иргэдийн эрүүл мэндэд учирч болох эрсдэлийг удирдах чиглэлээр Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг байгуулах;

6/коронавируст халдвар /Ковид-19/-ын эмчилгээ, оношилгооны төвийг бүсчилсэн хэлбэрээр аймаг орон нутагт байгуулж PCR-н оношлуур аппаратаар хангах;

7/орон нутгийн сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг хийж, Засаг дарга нарыг томилох асуудлыг шуурхайлах;

8/түлш, шатахуун, мах, гурил зэрэг гол нэрийн бүтээгдэхүүний хомсдол үүсгэхгүй, үнэ хөөрөгдөхгүй байхад чиглэсэн төлөвлөгөөг боловсруулах, нөөц бүрдүүлэх, хэрхэн хангах талаар цаашид авах арга хэмжээний саналаа Улсын Их Хуралд танилцуулах;

9/Ажилласан жил, нийгмийн даатгалыг нөхөн тооцох тухай хуулийн хэрэгжилтийн хугацааг хойшлуулах асуудлыг судалж, санал боловсруулан Улсын Их Хуралд танилцуулах;

10/ түр хугацаагаар хөдөө орон нутгаас ирсэн иргэд болон оюутнуудыг шинжилгээнд хамруулан гэрт нь буцаах арга хэмжээг ойрын хугацаанд зохион байгуулах;

11/коронавируст халдвар /Ковид-19/-ын вакциныг эхний ээлжинд худалдан авах чиглэлээр олон улсын байгууллагуудтай гэрээ хэлэлцээр байгуулах;

12/иргэд, олон нийтэд хувийн ариун цэврийг сахиж, хариуцлагатай байх, бусдын эрхийг хүндэтгэх талаарх мэдээлэл, сурталчилгааг идэвхжүүлэх;

13/Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж, эрдэмтэн судлаачдын саналыг харгалзан "Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хуулийн үйлчлэх хугацааг сунгах эсэх тухай саналаа Улсын Их Хурал /Түр хороо/-д хуулийн үйлчлэл дуусахаас өмнө танилцуулж шийдвэрлүүлэх;

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын холбогдох байнгын хороод болон Улсын Их Хурлын Түр хороо /Б.Баттөмөр/-нд даалгасугай.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг